

ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
1	7.3. Үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ бүхий цонх бий болгож, дугаар харгалзахгүй үйлчлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх	Төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэн авахад саадгүй хялбар байх	Хэлтсийн гадна машины зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн машин тавих тэмдэг, тэмдэглэгээтэй 2 зогсоолтой болсон. Үйлчилгээний заалны 5 цонх болон иргэдэд үйлчилгээ үзүүлдэг 3 өрөөний хаалган дээр хөгжлийн бэрхшээлтэй болон жирэмсэн ахмад настай хүмүүст дараалал харгалзахгүй үйлчилгэх зурагт тэмдэглэгээ байршуулсан. Хэлтсийн байрны гадна хаалганд тусламжын хонх буюу хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусламж хэрэгтэй иргэн тусламж авах шаардлагатай үедээ ашиглах хонхыг байрлуулж хэлтсийн жижүүрүүд туслан ажиллаж байна.
2	10.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ажлын цагт зохицуулалт хийх	Хэлтэсийн албан хаагчдын гэр бүлийн хүрээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний судалгааг гаргасан байна. Нийгмийн баталгааг хангаж дэмжих, амьжаргааг дээшлүүлэх ажлууд зохион байгуулах	Гэр бүлд нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байдаг 1 албан хаагч байдаг. Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч М.Ариунжаргалын охин байнгын асаргаанд байдаг. М.Ариунжаргалд хуульд заасны дагуу хорогдуулсан цагаар ажиллах боломжоор хангаж ажиллаж байна. Мөн хүүхдээ эмчилгээнд авч явахад нь хэлтсийн хэмжээнд дэмжлэг тусалцаа үзүүлдэг.

1.2. Дохионы хэлний хэлмэрч бэлтгэх сургалтад хаагчдыг шинээр нэмж сурах	Албан хаагчдад зориулсан дохионы хэлмэрчийн сургалт зохион байгуулагдсан байх	Дохионы хэлний хэлмэрч бэлтгэх анхан шатны богино хэмжээний сургалтыг 2025 оны 4-р сарын 14-ны өдрөөс 2 сарын хугацаанд аймгийн Насан туршийн боловсролын газартай хамтран зохион байгуулж хэлтсийн 10 албан хаагч хамрагдан суралцаж байгаа.
--	---	---

БИЕЛЭЛТ ГАРГАСАН

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН
ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭГЧ



М.АРИУНЖАРГАЛ